



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Хүнсний ногоо тариалах иргэдэд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд хүнсний нарийн ногоо тариалах хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх ажлыг хорооны хэмжээнд зохион байгуулсугай.

2.Хүнсний ногооны үр олгоход шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулах 483,700 (Дөрвөн зуун наян гурван мянга долоон зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тариалалтад олгох үрийг татан авах, тариалан эрхлэгчдэд олгох ажлыг шуурхай зохион байгуулж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллахыг 1 дүгээр хороо (Н.Нямзав)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон эргэн танилцуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 04 дугаар
захирамжийн хавсралт



ХҮНСНИЙ НОГОО ТАРИАЛАХ ИРГЭДЭД ҮР ОЛГОХОД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Үрсэлгээний сав 6*6*5 см 32 нүдтэй	ш	50	1,360	68,000
2	Үрсэлгээний сав d-150 мм	ш	200	440	88,000
3	Хөвдөн хөрс (17,5л)	уут	5	12,600	63,000
4	Багц зөвлөмж №12. Сайн чанартай үрслэг хийх тухай	ш	2	25,000	50,000
5	Бутон	ш	10	4610	46,100
6	Тасалгааны цэцгийн үр	ш	10	3050	30,500
7	Өргөст хэмхийн үр	ш	40	1690	67,600
8	Гоньдны үр	ш	10	1410	14,100
9	Вазилик үр	ш	10	1410	14,100
10	Яншуй үр	ш	10	1410	14,100
11	Бууцай үр	ш	10	1410	14,100
12	Помидорны үр	ш	10	1410	14,100
Нийт дүн					483,700